



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/199

Булган сум

Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоол "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай А/760 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл" байгуулж, салбар дундын оролцоог ханган ажиллахыг Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн орлогч даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж, "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл"-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023. оны  
03 дугаар сарын 29-ны өдрийн А/190 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“ЭХ,ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Салбар зөвлөлийн дарга:	Засаг дарга
Зөвлөлийн орлогч дарга	Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Гишүүд :	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга
	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга
	Гэр, бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Статистикийн хэлтсийн дарга
	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
	Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан ерөнхий мэргэжилтэн
	Эх, барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан ерөнхий мэргэжилтэн
	Холбогдох төрийн бус байгууллага (зөвшилцсөнөөр)





**ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЧИГ, ҮҮРЭГ**

- “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах
- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.
- Хуралдааныг шаардлагатай тохиолдолд тухай бүрд зарлан хуралдуулах
- Орон тооны бус салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар хурлын тэмдэглэл гарна. Хэлэлцсэн асуудлаарх холбогдох шийдвэрийг харьяа байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төр болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
- Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндэд зарцуулах санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ухуулга, нөлөөллийн ажил зохион байгуулах
- Эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээрх бодлогын баримт бичиг, тушаал, заавар, зөвлөмж, журам, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах
- Орон нутагт эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл болон арга хэмжээний төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж бусад төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнүүдтэй уялдуулах
- Аймгийн түвшинд эх, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үнэлгээ хийж, үр дүнг тооцон хэлэлцэж ажиллах
- “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний /2021-2024/ оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор хийгдэж буй төсөл, арга хэмжээнүүдэд хяналт тавьж дүн шинжилгээ хийх
- “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний үйл ажиллагааны үр дүнгийн тайланг холбогдох албан тушаалтнаар албажуулан тогтоосон хугацаанд Эрүүл мэндийн яам, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд тус тус хүргүүлэх